



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/ЧН


Улаанбаатар хот


Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Төсөв батлах тухай” 2018 оны 20/17 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Хөрөнгө оруулалтын ажлын зохион байгуулах тухай” А/137 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/137 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжих хот тохижилт, нийтийн аж ахуй, барилга засварын ажлын жагсаалтын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 76 дугаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зөвлөмжийг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж ажиллахыг Үнэлгээний хороо /Г.Ууганбаяр/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА.  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 08 сарын 27 өдрийн
#144 тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Г.Ууганбаяр	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга
	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Д.Лувсанчимэд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Билгүүн	Сүхбаатар дүүргийн 10 дугаар хорооны 7 дугаар хороолол 21-28 тоотод оршин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Г.Билгүүн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн